



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

2024 оны 11-р сарын 18

- Тендерийн нэр: **Их багтаамжийн “Метро”-г барьж байгуулах төсөл**
- Тендерийн дугаар: **НХААГ/20240101236**
- Тендер зарласан огноо: **2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр
13:00 цаг (Улаанбаатарын цагаар)**

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <https://tender.gov.mn>-д 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр нийтлэгдсэн тендер шалгаруулалтын баримт бичигт дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсныг үүгээр мэдэгдэж байна:

Одоогийн төлөвлөлттэй харьцуулахад бүтэн хэмжээний газар доогуур барилгын ажил нь цаашдын газар ашиглалт болон өргөтгөх тал дээр илүү үр ашигтай гэж үзэж байгаа тул энэхүү нэмэлт өөрчлөлтийг оруулж байна.

Тендерийн баримт бичигт дараах гол өөрчлөлтийг оруулав:

1. Гүүрэн байгууламж, түүний суурь, өргөгдсөн өртөө зэрэгт тавигдах техникийн шаардлагыг устгасан.
2. Тендерийн санал хүлээн авах эцсийн хугацаа болон тендерийн нээлтийн хугацааг Хавсралтад заасан хугацаагаар сунгав.

Худалдан авах ажиллагааны портал дээр нийтлэгдсэн тендер шалгаруулалтын баримт бичиг болон техникийн тодорхойлолтыг нэгтгэн харуулав.

Хавсралт: Тендер шалгаруулалтын баримт бичиг болон Техникийн тодорхойлолтод нэмэлт, өөрчлөлт оруулах



ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТОД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

ББ	НЭГДҮГЭЭР ШАТНЫ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ ОГНОО: 2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03	Нэмэлт, өөрчлөлт
ТШББ/ тендерийн мэдэгдэл	26.1 болон 26.2 Тендер хүлээн авах эцсийн хугацаа: Огноо: 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 11 цаг 00 минут Нээх огноо: 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 11 цаг 10 минутад нээнэ.	Тендер хүлээн авах эцсийн хугацаа: Огноо: 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 11 цаг 00 минут Нээх огноо: 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 11 цаг 10 минутад нээнэ.
Техникийн тодорхойлолт	4.2 Төслийн хэрэгцээ, шаардлага <u>Өртөө:</u> Өртөөний байршил, тоог ТЭЗҮ-ийг сайтар судалж, талбай судалгааг хийсний дараа шинэчлэн тогтооно. Одоогоор газар доор 5 өртөө, газрын түвшинд 1 өртөө, газраас өндөрт 8 өртөө барихаар төлөвлөж байгаа бөгөөд тендерийн шатанд өөрчлөгдөх магадлалтай.	<u>Өртөө</u> Өртөөний байршил, тоог ТЭЗҮ-д сайтар дүн шинжилгээ хийж, талбайн үнэлгээ хийсний дараа шинэчлэн тогтооно. Одоогийн байдлаар <u>газар доорх өртөө</u> барихаар төлөвлөж байгаа бөгөөд тендерийн шатанд өөрчлөлт оруулах боломжтой.
	4.3 Хүснэгт 1 Төсөлд тавигдах ерөнхий шаардлага • <u>Өртөөний тоо: 14 (Өргөгдсөн 8, газар доор 5, газрын түвшинд 1)</u> • <u>Дээд хурд (км/ц): 100 (газар доорх хэсэгт 80)</u>	• <u>Өртөөний тоо: 14 (газар доор)</u> • <u>Дээд хурд (км/ц): Газар доорх хэсэгт 80</u>
	5.1 Зураг төсөл (а) Барилга байгууламж, инженерийн шугам, сүлжээ, дэд бүтцийн дараах ажлуудын зураг төслийг иж бүрэн гүйцэтгэнэ: – <u>Гүүр, гүүрэн байгууламж</u> (с) Нэмэлт судалгаа: Гүүрийн суурийн болон туннелийн, төслийн барилга угсралтын явцад өмнөх судалгаанд тулгуурлан хийсэн дүгнэлтэд тусгаагдаагүй хүндрэлтэй нөхцөл байдал үүсвэл Нэмэлт болон бусад шаардлагатай судалгааг хийх.	(а) <u>“Гүүр, гүүрэн байгууламж” хассан</u> (с) <u>“гүүрийн суурийн болон” хассан</u>
	5.3 Барилга угсралт (5.3.1 Барилга угсралтын ажил) (b) <u>Газрын гадаргын түвшин болон өргөгдсөн гүүр, гүүрэн байгууламжийн барилга угсралт, эдгээрийн бүх газар шорооны болон дагалдах ажлыг гүйцэтгэх.</u> (d) <u>Өртөөний барилга байгууламжийг</u>	<u>“(b)” Хассан</u> (г) <u>Өртөөний газар доорх барилга байгууламж барих, түүнд холбоотой бүх барилгын ажлыг гүйцэтгэх</u>



Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт

	<p><i>барих, үүнд газар доорх, газрын түвшин, өргөгдсөн өртөөнүүд хамрагдаж, бүх барилгын ажлыг гүйцэтгэх</i></p>	
--	---	--